

“СУМ-НЭГДЛИЙН ТОГТОЛЦОО (МАЛЧИН ӨРХ-НЭГДЭЛ-УЛС)” БҮТЭЭЛИЙН ТУХАЙ ШҮҮМЖ

Ц. ГАНТУЛГА

МУИС-ийн Түүхийн тэнхим дээр 2018-2022 онд БШУЯ-ны ШУТС-гийн санхүүжилтээр “Нэгдэлч малчдын түүхийг шинээр эргэн харахуй” сэдэвт суурь судалгааны төсөл хэрэгжиж, энэ хүрээнд хийсэн судалгааныхаа үр дүнд тулгуурлан 2023 онд Н.Алтантөгс, П.Дэлгэржаргал, Р.Төрдалай, Б.Чинзориг нар “Сум-нэгдлийн тогтолцоо (Малчин өрх-Нэгдэл-Улс)”⁴⁷ гэх томоохон нэгэн сэдэвт сонирхолтой бүтээл туурвин нийтлүүлжээ. Төслийн удирдагчаар доктор П.Дэлгэржаргал ажилласан ажээ.

Энэхүү бүтээл ойрд харагдаагүй шинэлэг, сонирхолтойн дээр манай ахмад үеийнхний мэддэг мэт боловч дотоод амьдралын нарийн ширийн зохицуулалтыг нь тэр бүр мэддэггүй “Сум-Нэгдэл”-ийн тухай тусгайлан судалснаараа чухал ач холбогдолтой гэдгийг юуны өмнө цохон тэмдэглэе. Эл суурь судалгааны томоохон бүтээл нь 6 бүлэг, 26 зүйл, товчилсон үг, хүснэгтийн жагсаалт, өмнөх үг, удиртгал, дүгнэлт, ном зүй, нэрсийн хэлхээнээс бүрдэх В5 хэмжээтэй, 432 нүүр, 38,6 х.х-тай бөгөөд бүтээлийн IV, V бүлэг болон I бүлгийн 3 дугаар зүйлийг доктор Н.Алтантөгс, II бүлгийг доктор П.Дэлгэржаргал, III бүлэг болон I бүлгийн 1, 2 дугаар зүйлийг доктор Р.Төрдалай, VI бүлэг болон I бүлгийн 4 дүгээр зүйлийг доктор Б.Чинзориг нар тус тус бичжээ.

Урьд нь манай түүх бичлэгт тухайн цаг үеийн үзэл суртал, эрх баригч намын эрх ашгийг эрхэмлэсэн албан түүхийн байдлаар ХААН, “хоршоолсон ард” гэгдэж байсан нэгдэлч малчдын асуудлыг магтан дуулсан, ерөнхийлөн илсэн, өрөөсгөл хандлагаар авч үзэж ирснийг бид мэднэ. Харин эдгээр эрдэмтэд түүх судлалын өнөөгийн шаардлага, шинэ үзэл сэтгэлгээний үүднээс асуудалд хандаж, социализмын үеийн ХААН болон нэгдэлч малчдын амьдралын түүхэнд тулгуурлан, Монголын мал аж ахуйн салбарын түүхийг судалж, дүн шинжилгээ хийхийг зорьсон нь сайшаалтай. Чингэхдээ Хөвсгөл аймгийн Мөрөн хот, Тосонцэнгэл сум, Архангай аймгийн Цэцэрлэг хот, Ихтамир зэрэг сумдад хээрийн судалгаа хийж, аман түүхийн судалгааны орчин үеийн арга зүйн дагуу судалгааны бааз, мэдээллийн сан үүсгэн, нэгдлийн түүхэнд холбогдох төв, орон нутгийн цөөнгүй архивт ажиллаж, эх баримтуудтай танилцаж судалгаагаа хийсэн байна⁴⁸. Энэ хүрээнд, МУУТА, УТНОНББТ, Гадаад харилцааны төв архив,

⁴⁷ Алтантөгс Н., Дэлгэржаргал П., Төрдалай Р., Чинзориг Б. (2023). *Сум-нэгдлийн тогтолцоо* (Малчин өрх-Нэгдэл-Улс). Ред. П.Дэлгэржаргал. Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар:

⁴⁸ Алтантөгс Н., Дэлгэржаргал П., Төрдалай Р., Чинзориг Б. (2023). *Сум-нэгдлийн тогтолцоо* (Малчин өрх-Нэгдэл-Улс). Ред. П.Дэлгэржаргал. Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар, т. vi-vii

Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын архив, Архангай, Төв, Хөвсгөл аймгийн архив, мөн түүнчлэн ОХУ-ын Буриадын улсын архивд хадгалагдаж буй хөдөө аж ахуйн нэгдлийн түүхэнд холбогдох БНМАУ-ын УААА дахь сум-нэгдлийн тогтолцоо, газрын харилцаа, Монгол-Зөвлөлтийн мал аж ахуйн бүтээгдэхүүний худалдааны тухай гэх зэрэг их хэмжээний баримтуудыг шинээр илрүүлж, судалгааны эргэлтэд анх удаа оруулжээ.

Монголын мал аж ахуйн түүхэнд анх удаа ХХ зууны 2-р хагасын эхэнд малчдын хувийн өмч хөрөнгө болох малыг нийгэмчилж “хоршоолсон” нь “олон мянганаар уламжилж ирсэн малчдын амьдралын тогтсон зохион байгуулалтыг өөрчилж, мал аж ахуйн үйлдвэрлэлд чанарын шинэчлэл гаргасан томоохон үйл явдал байсан”⁴⁹ гэдэгтэй маргах аргагүй юм. Гэхдээ бид тэрхүү том өөрчлөлтийн гүн рүү нэвтэрч, түүний үр дагаврыг тал бүрээс нь бүрэн дүүрэн судалж, үнэлж дүгнэж чадаагүй байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Тиймээс энэхүү төслийг хэрэгжүүлсэн эрдэмтэн судлаачид ХААН-д суурилсан, Нэгдэлч малчид, Улс гэх 3 тал оролцсон өвөрмөц тогтолцоог нэг бүхэллэг болгон судлах үндсэн дээр “социализмын үеийн нэгдэл болон нэгдлийн гишүүн малчдын түүхийг бүхэлд нь нэгтгэн дүгнэж, ХААН-ийн Монголын нийгэм, эдийн засаг, соёлын хөгжилд гүйцэтгэсэн үүргийг тодорхойлох”-ыг эрмэлзсэн нь тун чухал юм. Энэ утгаараа уг нэгэн сэдэвт зохиолд олон асуудлыг шинээр авч үзэхийг оролдсон байна. Үүнийг бүтээлийн агуулга бүрнээ илэрхийлэх бөгөөд энэ бүхнийг зохиогчдын тодорхойлсончлон дурдвал:

- Нам, төрөөс нэгдлийг хөгжүүлэх талаар явуулсан бодлогод дүн шинжилгээ хийж, 1960-1992 онд оршин тогтнож байсан сум-нэгдэл нь газар нутаг, хүн ам, удирдлагын нэгдсэн тогтолцоо бүхий захиргаа-аж ахуйн тогтолцоо байсныг тодруулсан,
- Захиргаа-аж ахуйн хосолмол бүтэц бүхий сум-нэгдлийн тогтолцоо нь захиргааны эрх мэдлээ мал аж ахуйн үйлдвэрлэлд хэрэглэх эрхтэй сум-нэгдлийн даргад асар их эрх мэдэл төвлөрүүлж, “захиргаадалтын” дэглэмийг бэхжүүлж өгсөн байна. Удирдлагын энэ тогтолцоо нь мал аж ахуйн үйлдвэрлэлийг захиргааны аргаар удирдаж, нөөцийг дээд зэргээр дайчлан улсын төлөвлөгөөг биелүүлэх боломжийг нэгдэлд олгож байсныг шинжлэн судалсан,
- 1963 оноос нэвтрүүлсэн хөдөлмөр зохион байгуулалт, хөлс төлөлтийн шинэ тогтолцоо нь хөдөлмөрийн нөөцийг дайчлах, мал аж ахуйн бүтээгдэхүүний өөрийн өртгийг бууруулах, бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх зарчимд суурилж байсныг судлан тодруулсан,
- 1960-аад оноос сум-нэгдлийн газрын харилцааны эрх зүйн үндэс бүрэлдсэн ба 1960-1990 онд хамаарах сум-нэгдлийн газрын харилцааны зохицуулалт, газар эзэмшлийн онцлог, хэлбэрүүд, нэгдэлч малчдын газар ашиглалт, сум-нэгдлийн тогтолцооны үеийн газрын маргаан, түүнийг

⁴⁹ Алтантөгс Н., Дэлгэржаргал П., Төрдалай Р., Чинзориг Б. (2023). *Сум-нэгдлийн тогтолцоо* (Малчин өрх-Нэгдэл-Улс). Ред. П.Дэлгэржаргал. Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар, т. xiii

хэрхэн шийдвэрлэж байсан асуудлыг түүхэн баримтад тулгуурлан тодотгон гаргасан,

- Малчин өрхийн түвшинд сум-нэгдлийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн хөдөлмөр зохион байгуулалт, нэгдэлчний өрхийн орлого, зарлага, өрхийн амьжиргаанд амины малын гүйцэтгэж байсан үүргийг тодруулсан,
- Нэгдлийн түвшин дэх судалгаагаар нэгдлийн орлого ба зарлагын бүтцийг судалж, ХААН нь аж ахуйн нэгжийн хувьд хэр үр ашигтай тогтолцоо байсныг тодруулсан. Түүнчлэн мал аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх тогтолцоог хамтад судалсан,
- Судалгааг улсын ба бүс нутгийн түвшинд авч үзэхдээ сум-нэгдэл бүр улсын төвлөрсөн төлөвлөгөө, улсын бэлтгэлийн тогтолцоогоор дамжуулан Зөвлөлтийн Транссибирийн төмөр замтай нягт интеграцид орсныг тодруулсан,
- Нэгдлүүд нь сургууль, эмнэлэг, цэцэрлэг, улаан булан, халуун усны газар зэрэг соёл ахуйн барилга байгууламжуудыг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах зэргээр хөдөөгийн хөгжилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн явдлыг шинжилсэн,
- Нэгдлийн түүхтэй холбоотой баримт бичиг, тоон мэдээлэл бүрдүүлэхэд анхаарч, түүхэн тоон аргыг хэрэглэхийн зэрэгцээ нэгдэлч малчдын боловсрол, соёл, эрүүл мэнд зэрэг нийгмийн өдөр тутмын амьдралын өөрчлөлтийн түүхийг тодруулахдаа аман түүхийн мэдээ баримтыг өргөн ашигласан ажээ⁵⁰.

Тус бүтээлийн “Малчнаас нэгдэлчин хүртэл (1933-1959 он)” гэх тэргүүн бүлэгт, Монгол дахь “хамтралжуулах хөдөлгөөн”-өөс эхлэн ардын үйлдвэрлэлийн нэгдэл (АҮН), ХААН-ийн хэлбэрээр цаашид үргэлжилсэн хамтын аж ахуйн түүхийг шат дараалан тоймлон авч үзжээ (т.3-70). Гэвч энд цаашид засууштай нэг техник алдаа буй нь хамтрал, коммуны үеийг нэг үе болгосон атлаа бүлгийн гарчигт он цагийн хамаарал нь тусгагдсангүйн дээр 1930 оноос эхлүүлсэн нь хэр оновчтой болохыг тунгааж үзэхэд илүүдэхгүй мэт санагдана. Учир нь хөрөнгө хураах үйл явцтай зэрэгцээд 1929 оноос хамтрал коммун байгуулагдаж эхэлсэн байдаг. Тэрчлэн АҮН-ийг 1933 оноор зааглан үзсэний үндэслэл тодорхой харагдахгүй байна. Ер нь хамтрал коммуныг өөрчлөн байгуулах ажил 1932 оны зунаас эхэлж, мөн оны намраас үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэрээр хэрэгжиж эхлэн, 1932 оны 10-р сард АҮН-ийн дүрмийг батлан гаргаснаар албажсан билээ. Харин хоршооллын байгууллын цаашдын түүхэн хөгжлийг үечлэн үзэхдээ, Хөдөө аж ахуйн нэгдлийн үе (1955-1959), Сум-нэгдлийн үе (1960-1992) гэсэн шинэлэг санал дэвшүүлсэн нь судалгааны үр дүнтэй уялдаж байна. “Нэгдэлжүүлэх хөдөлгөөн” ардын хувийн аж ахуйтнуудыг “албадлага, захиргаадалтын арга хэмжээ хосолсон бодлого, үйл ажиллагааны үр дүнд хэрэгжсэн” болохыг архивын болон аман түүхийн мэдээ баримтаар

⁵⁰ Алтантөгс Н., Дэлгэржаргал П., Төрдалай Р., Чинзориг Б. (2023). *Сум-нэгдлийн тогтолцоо* (Малчин өрх-Нэгдэл-Улс). Ред. П.Дэлгэржаргал. Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар., т. xiii-xiv

нотлохыг хичээсэн нь зүй ёсны хэрэг юм. Харин бүтээлийн агуулгад 1992 он хүртэлх нөхцөл байдлыг, тухайлбал гэрээ, түрээсийн бодлого хэрэгжүүлсэн, нэгдэл тарсан түүхийг тусган оруулж өгсөн бол илүү сонирхолтой байх байв. Магадгүй энэ нь дараагийн бүтээлд хамрагдах тул үлдээсэн буй за.

“Нэгдэлч малчдын талаар явуулсан нам, төрийн бодлого (1960-1990)” гэх дэд бүлэгт (т.72-117), ХААН-ийн эрх зүйн орчин, ХААН-ийн Холбооны зөвлөл, Сум-Нэгдэл: Захиргаа аж ахуйн тогтолцоо, ХААН-ийн хөдөлмөр зохион байгуулалт, хөлс төлөлтийн тогтолцоо зэргийг судлан үзжээ. Энэ үед нэгдлийн хөрөнгөөр сумын төвийг бүтээн босгох бодлого хэрэгжүүлсэн, энэ нь шинэ төв суурин, соёл, үйлчилгээ, дэд бүтэц бий болоход чухал хувь нэмэр оруулсан нь бодит үйл явц бөгөөд мөн “улсаас багагүй хэмжээний татаас авдаг байсан”⁵¹ нь ч үнэн билээ.

Бүтээлд 1960 оноос хэрэгжиж эхэлсэн нэг сум–нэг нэгдэл бодлогын үр дүнд энэхүү хосолсон өвөрмөц тогтолцоо бодитойгоор төлөвшин бүрэлдэн тогтсон болохыг тал бүрээс нь судлан тодорхойлсон нь яах аргагүй шинэлэг санал дүгнэлт мөн. Социалист байгуулалтын үеийн “нэгдэл нь сум-нэгдлийн тогтолцооны дотор оршиж, хоршооллын шинж чанараа алдан, өмнөх үеийн ардын үйлдвэрлэлийн нэгдлээс огт өөр шинж чанартай, “төржсөн” хоршооллын байгууллага болж хувирсан” гэх дүгнэлттэй санал нэг байна. Тиймээс сум-нэгдлийн тогтолцоо нь мал аж ахуйд суурилсан бүхий л нөөцийг дээд зэргээр дайчлан, улсын улсын бэлтгэлийн төлөвлөгөөг биелүүлэхэд үйлчилж, эрх мэдлийн төвлөрөл, “захиргаадалтын” дэглэмийг амилуулан хэрэгжүүлэх боломжийг олгож байсан гэдгийг бүтээлд тодорхой гаргасан байна.

Мөн түүнчлэн энэ бүлэгт 1963 оноос нэвтрүүлсэн “ХААН-ийн хөдөлмөр зохион байгуулалт, хөлсний системийг сайжруулах тухай” тогтоолоор малчдын хөдөлмөрийг суурь, хэсгээр зохион байгуулах болсон хийгээд хөдөлмөрийн хуваарьт тулгуурлан малчдын бүтээмжийг дээшлүүлэх зарчмыг хэрэгжүүлэх болсон зэрэг асуудлыг тусгайлан авч үзжээ. Энэ үндсэн дээр зохиогч “сум-нэгдлийн захиргааны хосолмол засаглал нь нэгдлийн сууриудыг боломжит хамгийн бага өртгөөр, хамгийн их мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлүүлэх улс төр-эдийн засгийн арга...ХААН-үүдийг БНМАУ болон ЗХУ-ын аж үйлдвэрийн тогтолцоотой нягт уялдуулсан улсын бэлтгэлийн тогтолцоо”⁵² болж байсан гэж үзсэн нь бодит байдалд нийцнэ.

Социализмын үеийн ХААН хийгээд төр-улсын харилцаанд нэг өвөрмөц асуудал байсан нь нэгдлүүдийн газар эзэмшил, малчдын бэлчээр нутгийн зохицуулалт болно. Энэ асуудлыг номын **“Сум-нэгдлийн газрын харилцаа (1960-1990)” гэх гутгаар бүлэгт** судлан үзсэн нь цаашдын судалгаанд зохих

⁵¹ Алтантөгс Н., Дэлгэржаргал П., Төрдалай Р., Чинзориг Б. (2023). *Сум-нэгдлийн тогтолцоо* (Малчин өрх-Нэгдэл-Улс). Ред. П.Дэлгэржаргал. Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар, т. 86

⁵² Алтантөгс Н., Дэлгэржаргал П., Төрдалай Р., Чинзориг Б. (2023). *Сум-нэгдлийн тогтолцоо* (Малчин өрх-Нэгдэл-Улс). Ред. П.Дэлгэржаргал. Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар, т. 411

хувь нэмэр болох нь дамжиггүй (т.136-172). Зохиогч “Сум-нэгдлийн удирдлагын тогтолцоо нь нэгдлийн малчдыг эдийн засгийн хяналтаас гадна захиргааны хяналтад оруулж, захиргааны аргаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг удирдах, нэгдлийн малчдыг “хамжлагачлах”, нөөцийг захиргааны аргаар дайчлах боломжтой байсан. 1960-1992 оны хооронд оршин байсан сум-нэгдэл бол аж ахуй-захиргаа хосолсон нэгдмэл тогтолцооны үүргийг гүйцэтгэж байсан” хэмээн үзсэнд тал өгч болно. Энэ үед улсын зүгээс, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн хэрэгслийн салшгүй хэсэг болох бэлчээрийн газрыг сум-нэгдлээр дамжуулж эзэмшүүлэн ашиглах болсон онцлогтой билээ. “Сум-нэгдлийн эзэмшил газарт зөвхөн бэлчээр төдийгүй, тариалангийн талбай, суурьшлын бүс, өвөлжөө, хаваржааны газар, гадаргын ус, ойн нөөц орж байлаа. Бэлчээр зохицуулалт буюу малчид хаана нутаглах, оторлох, өвөлжиж, хаваржих асуудал сум-нэгдлийн болон бригадын удирдлагын бүрэн эрх мэдэлд хамаарч байв. Ийнхүү малчид малаасаа хагацсан төдийгүй ардын аж ахуйтны үед уламжлалт хэв хуулиар зохицуулж ирсэн бэлчээр болон өвөлжөө, хаваржаа эзэмших эрх нь сум-нэгдлийн мэдэлд шилжжээ” хэмээн зохиогч дүгнэсэн нь бодит үндэслэлтэй юм. Гэхдээ амьдрал дээр энэ нь хэр хэрэгждэг байсныг байгаль газар зүйн онцлогтой нь холбон, янз бүрийн бүс нутгийн жишээн дээр судлан тодруулах шаардлагатай болов уу. Ялангуяа баруун Монголын уулархаг бүсэд оршдог нэгдлүүд өгсөх, уруудах чиглэлтэй холын нүүдэл хийхээс аргагүй нөхцөлд аж төрдөг, тиймээс байгалийн эрхшээлд захирагддаг, нүүдлийн уламжлалт хэвшлээ хадгалсан шинжтэй байсан гэдгийг бодолцох хэрэгтэй. Тийм хэдий ч ХАА-н эдэлбэр газрыг улсын хэмжээнд бүгдийг нэгдэл болон сангийн аж ахуй, тэжээлийн аж ахуйнууд бүрнээ хуваан эзэмшиж байсан нь бодитой билээ. Гэсэн атлаа БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1960 оны 7-р сарын 5-ны өдрийн 298 дугаар тогтоолоор, бүх сумын хилийг тогтоож, нийт нутаг дэвсгэр дээр аж ахуй хоорондын газар зохион байгуулалт хийсэн боловч бодит байдал сум-нэгдлүүдийн эзэмшил газрыг салгах буюу нэгтгэхдээ тооцоо судалгаагүй, хайнга хандсанаас болж, хил зааг нь тодорхой бус үлдэж, үүний улмаас 1960-1980-аад онд сум-нэгдлүүдийн хооронд газар нутгийн маргаан зөрчил бишгүй гарч байсан болохыг бүтээлд дурдан тэмдэглэжээ. Амьдрал дээр ийм жишээ цөөнгүй бөгөөд үүнийг цаашдаа шигтгэн оруулж өгвөл бүтээлийн чанар чансаа хийгээд өгүүлэн буйг санааг батлан тодорхойлох бодит баримт болох билээ. Нөгөөтэйгүүр тухайн үеийн БНМАУ-д газар эдэлбэрийн хууль батлагдан мөрдөгдөж байсан хэдий ч газрын харилцааны зохицуулалт төлөвшин тогтоогүй, “суурин болон нүүдлийн гэсэн газрын харилцааны холимог хэв маяг зэрэгцэн оршиж”⁵³ байсантай холбоотой асуудлуудыг цаашид лавшруулан судлууштай юм.

“Сум-нэгдлийн малчдын мал аж ахуйн үйлдвэрлэл” хэмээх дөтгөөр бүлэгт, МAA-н үйлдвэрлэлийн хэрэгсэл, 5 жилийн төлөвлөгөө ба малчид, МAA-н үйлдвэрлэлийн үе шат, МAA-н бүтээгдэхүүний өртөг ба нэгдлийн ашиг

⁵³ Алтантөгс Н., Дэлгэржаргал П., Төрдалай Р., Чинзориг Б. (2023). *Сум-нэгдлийн тогтолцоо* (Малчин өрх-Нэгдэл-Улс). Ред. П.Дэлгэржаргал. Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар:, т. 140

зэрэг нэлээд нарийн асуудлуудыг тухайлан авч үзсэн байна (т.186-219). Тухайн үед улсын төвлөрсөн төлөвлөгөөг социалист эдийн засгийн интеграцитай нягт уялдуулан зохиодог, УААА-н бүх салбарыг, түүний дотор сум-нэгдлээр дамжуулан эгэл малчдыг хүртэл бүхэлд нь хамруулж байсан билээ. “Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүх үе шатыг, түүнээс гарах бүтээгдэхүүнийг улсын төлөвлөгөө, үйлдвэрлэлийн даалгаврын тоо хэмжээгээр тодорхойлж”, МАА-н үйлдвэрлэлийн бүхий л үйл ажиллагаа “төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай нягт, салшгүй холбогдож” байсныг зохиогч баримт, нотолгоотой дэлгэн үзүүлжээ. Тэрчлэн улсаас өгсөн төлөвлөгөө ба үйлдвэрлэлийн даалгавар нь гүйцэтгэлийн хяналт, урамшууллын ба төлбөрийн тогтолцоогоор дамжуулан мал аж ахуйн үйлдвэрлэлийг удирдах эдийн засгийн албадлагын хатуу системийг үүсгэсэн, үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл болох малыг нийгэмчилж, мал аж ахуйн эдэлбэр газрыг сум-нэгдэлд эзэмшүүлснээр малчид бүхэлдээ нэгдлийн хөлсний ажилчид болон хувирч, тэдний бүтээсэн нэмүү өртөг үйлдвэрлэлийн хэрэгслийг эзэмшигчдийн мэдэлд шилжсэн” нь үнэн билээ.

Гэхдээ малчдыг “амины малаа бэлчээх газаргүй”⁵⁴ гэж дүгнэсэн нь арай өрөөсгөл, хэтийдсэн мэт. Зохиолд “малчдад хувьдаа амины цөөн тооны мал өмчлөх, хувийн бяцхан аж ахуйгаа нийгмийн малтай хамтатган маллах эрхийг нэгдлийн дүрмээр олгож байв” хэмээн бичсэн дүгнэлт мөн буй. Харин “мал өсгөх төлөвлөгөө ба үйлдвэрлэлийн даалгавар нь зайлшгүй биелэгдэх ёстой учраас энэ бол зөвхөн төлөвлөгөө төдийгүй, хөлсний малчин цалин авахын тулд хийж гүйцэтгэх ёстой хамгийн бага ажлын хэмжээ юм”⁵⁵ гэснийг “албадлагын хөдөлмөр” хэмээвэл зохилтой санагдана. ХААН-ийн гишүүн хөлсний малчин хүн зохиогчийн хэлсэнчлэн үнэхээр “унтах нойроо умартан” бүх ард түмний төлөвлөгөөг биелүүлэхээр зүтгэхээс өөр аргагүйд хүрдэг байсныг⁵⁶ яагаад ч үгүйсгэх аргагүй юм. Энэ мэтийг цаашид сайтар нягтлан судална биз ээ.

Тухайн үед нэгдэлч малчдын хөлс хүчээ шавхан бий болгосон мал аж ахуйн бүхий л бүтээгдэхүүний өртөг улсын бэлтгэлийн үнээс доогуур байх “зарчимтай” байв. Энэ нь ямар ч нөхцөлд дундаас нь ашиг олоход чиглэсэн хорон арга байсан гэж хэлж болно. Үүнийг бүтээлд тодорхой жишээ баримттай гаргаж тавьсан нь шинэлэг бөгөөд зүй ёсны хэрэг юм. “Малчин хүний хүнд хэцүү, цалин багатай хөдөлмөрийн үр дүнд мал аж ахуйн бүтээгдэхүүн асар хямд үнэтэй бүтээгдэж, улсын төсвийн орлогын томоохон эх үүсвэр болж байсныг” хэнбугай ч үгүйсгэх аргагүй билээ.

“Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг ба сум-нэгдлийн мал аж ахуйн бүтээгдэхүүн” гэх 5-р бүлэгтээ, ХААН ба Улсын бэлтгэлийн систем, МАА-н таваарын бүтээгдэхүүний экспорт, МАА-н бүтээгдэхүүний дотоодын хэрэглээний

⁵⁴ Алтантөгс Н., Дэлгэржаргал П., Төрдалай Р., Чинзориг Б. (2023). *Сум-нэгдлийн тогтолцоо* (Малчин өрх-Нэгдэл-Улс). Ред. П.Дэлгэржаргал. Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар., т. 413

⁵⁵ Алтантөгс Н., Дэлгэржаргал П., Төрдалай Р., Чинзориг Б. (2023). *Сум-нэгдлийн тогтолцоо* (Малчин өрх-Нэгдэл-Улс). Ред. П.Дэлгэржаргал. Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар., т. 197

⁵⁶ Алтантөгс Н., Дэлгэржаргал П., Төрдалай Р., Чинзориг Б. (2023). *Сум-нэгдлийн тогтолцоо* (Малчин өрх-Нэгдэл-Улс). Ред. П.Дэлгэржаргал. Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар., т. 207

тухай асуудлыг багтаан оруулж судлан гаргажээ (т. 242-260). Улсын бэлтгэлийн тогтолцоо нь БНМАУ-ын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн амин судал болж, түүгээр дамжуулан Монголын мал аж ахуйн бүтээгдэхүүн дотоодын болон экспортын хэрэгцээг хангаж байсан билээ. Бүтээлд, 1960-1970-аад оны үед Монголын мал аж ахуйн бүтээгдэхүүн ихэвчлэн ЗХУ руу экспортод гарч байсан бол үйлдвэржүүлэх бодлогын хэрэгжилтийн үр дүнд 1970-80-аад он гэхэд үндсэн урсгал нь өөрчлөгдөж, малын аж ахуйн түүхий эдийг дотоодын үйлдвэрүүд хүлээн авч боловсруулан, бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсон нь түүхэн томоохон өөрчлөлт байсныг тоо баримт түшин тодорхой гаргасныг сайшаан тэмдэглэе. Энэ утгаараа нэгдэлч малчдын хүч хөдөлмөрөөр бий болгосон баялаг улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх, хүн ардынхаа эрэлт хэрэгцээг хангах зэрэг олон талын үйл хэрэгт ихээхэн хувь нэмэр оруулсныг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй юм. Нөгөөтэйгүүр зохиогчдын онож тодорхойлсончлон, “сум-нэгдлүүд өөрийн малчдын хөдөлмөрийг “мөлжсөний” үр дүн”-д⁵⁷ боловсрол, соёл, эрүүл мэнд, ахуй үйлчилгээ зэрэг олон чиглэлээр бүтээн байгуулалт өрнүүлж, хөдөөгийн хөгжилд дэвшил авч ирснийг дурдах хэрэгтэй.

“ХААН-ийн нийгмийн асуудлууд” гэх 6-р бүлэгт, хүн амын төрөлт, нас баралт, өсөлт; Хөдөлмөрийн нөөц ба дотоод шилжих хөдөлгөөн; Эрүүл мэнд; Боловсрол; Хөдөлмөрийн харилцаа, тэтгэвэр тэтгэмж; Социалист өмчийн эсрэг гэмт хэрэг зэрэг өргөн хүрээтэй нийгмийн асуудлын талаар тусгайлан судалж гаргасан нь сайшаалтай (т.261-409). Энэ бол нийгмийн амьдралын нэг тал, бодлого, шийдвэр, үйл хэргийн бодит тусгал илэрхийлэл, үр дагаврыг тодорхойлж болох жишээ баримт болох тул зүй ёсоор авч үзэх учиртай. Тиймээс зохиогч энэ бүхнийг тодорхой жишээ, тоо баримт, бодит нөхцөл байдал зэрэгт тулгуурлан тусгайлан судалж гаргажээ. Өргөн уудам нутагтай Монгол орныг хамарсан боловсрол, соёл, ахуй үйлчилгээ, эрүүл мэндийн салбар, дэд бүтцийг бий болгоход сум-нэгдлүүд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн, сум-нэгдлийн захиргаа, аж ахуйн барилгууд, дэлгүүр, гуанз, мал эмнэлгийн газар, мал үржүүлгийн газар, хүүхдийн цэцэрлэг, сургууль, сурагчдын дотуур байр, эмнэлэг, эхчүүдийн байр, улаан булан, клуб, номын сан, халуун усны газар зэрэг нийгэм, ахуй соёлын барилга байгууламжуудыг барьж байгуулахад нэгдлүүд ихээхэн хүч чармайлт, хөрөнгө мөнгө зарцуулсан болохыг бүтээлд тусган оруулсан нь зүйн доторх хэрэг юм. Гэхдээ сум-нэгдлийн төвд баригдсан барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалтаас нэгдлийн мэдэлд үлдсэн зүйл байсан эсэх, улсын мэдэлд авсан бол ямар харилцаа үйлчилж байсан зэргийг цаашид лавшруулан судлууштай санагдана.

Социализмын жилүүдэд буй болсон нэг шинэ үзэгдэл, хүндрэлтэй асуудал бол хүн амын шилжилт хөдөлгөөн, төв рүү тэмүүлэх хандлага, ажиллах хүчний хомсдол дутагдал, түүнийг нөхөн хангах явдал байсан билээ. Бүтээлд эдгээр

⁵⁷ Алтантөгс Н., Дэлгэржаргал П., Төрдалай Р., Чинзориг Б. (2023). *Сум-нэгдлийн тогтолцоо* (Малчин өрх-Нэгдэл-Улс). Ред. П.Дэлгэржаргал. Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар:, т. 414

хүндрэлтэй асуудлын үүсэл, бодит нөхцөл байдал, авч хэрэгжүүлж асан арга хэмжээ зэргийг баримт түшин тодорхой өгүүлжээ. Тухайлбал, ХААН-үүдийг ажиллах хүчнээр хангахын тулд залуу малчны сургууль, илгээлтийн эздийн хөдөлгөөн, зохион байгуулалттайгаар малчин элсүүлэх, суртал ухуулгын зэрэг олон төрлийн арга хэмжээ авч байсны дээр захиргааны төрөл бүрийн аргуудыг хавсран хэрэглэхээс аргагүйд хүрч байсныг тусгайлан авч үзсэн байна. Энэ бүхэн бодит үнэн бөгөөд одоо ч суурь асуудал нь оршоор байгаа билээ. Нөгөө талаар нэгдлүүд малчдын боловсрол, эрүүл мэндэд санаа тавих болсноор урьд байгаагүй амжилт олж, хөдөөгийн хүн ам эрүүлжин, өсөж, малчдын бичиг үсэгт тайлагдан, ахуй, соёлд нь ихээхэн ахиц дэвшил гарсныг яагаад ч үгүйсгэх аргагүй гэдгийг бүтээлээс тодорхой харж болох байна.

Нэгдэлч малчид үлгэрчилсэн дүрэм ёсоор хөдөлмөр өдрөө үнэлүүлэн, тогтмол цалин хөлс авдаг, тэтгэвэр тэтгэмж хүртдэг болсон хэдий ч энэ нь ямар өрөөсгөл талтай байсныг эл бүтээлээс олж үзэж болно. Харамсалтай нь малчид нэгдлийн үйлдвэрлэлийн төлөвлөгөө, нормыг биелүүлэхийн тулд бүх хөлс хүчээ шавхан дайчилж ажиллаж байсан боловч түүнийг хэзээ ч бодитойгоор үнэлж ирээгүй, “чадлынхаа хэрээр хөдөлмөрлөж, хөдөлмөрлөснийхөө хэрээр авах” зарчим нь хоосон тунхаглал байсны бодит жишээ нь малчдын хөдөлмөрийн үнэлгээ билээ.

ХААН-ийн үлгэрчилсэн дүрэм ёсоор тухайн үед нийгмийн социалист өмчийн нэг хэлбэр болох нэгдлийн өмч хөрөнгийг нүдлэн хамгаалах нь малчин хүн бүрийн ариун үүрэг байсан бөгөөд “нэгдлийн үйлдвэрлэлийн тогтолцоо, зохион байгуулалт, хөдөлмөрийн нөхцөл байдал, онцлог малчдыг “ариун үйл хэргээ” хөсөрдүүлсэн “гэмтэн” болгон хувиргахад ихээхэн нөлөөлж байсан” гэдэгтэй санал нийлэхээс аргагүй юм. Социалист өмчийн зүсээ хувиргасан нэгээхэн хэсэг нь болох нэгдлийн малыг алдсан, хорогдуулсан, үрэгдүүлсэн малчин хүн наад зах нь өр төлбөрт унахаас эхлээд “социалист өмчийг ашиглан шамшигдуулсан”⁵⁸ гэмт хэрэгтэн болдог байсныг бүтээлд хууль эрх зүйн орчин, бодит жишээ баримт түшин гаргажээ.

Зохиогчид сум-нэгдлийн тогтолцооны сул тал нь уг тогтолцоо “үйлдвэрлэл” эрхлэгч-нэгдэлчин-малчин хүний төлөө байгаагүйд оршиж байсныг оновчтой дүгнэн тодорхойлжээ. Эл тогтолцоо улсын бэлтгэл, ноогдол, төлөвлөгөө биелүүлэх явдлыг гол болгон, хүчлэн шахаж хэрэгжүүлэх засаг захиргааны механизм байсан тул үйлдвэрлэн бүтээсэн бүхний эцсийн хэрэглэгч нь улс, цаашилбал хилийн чанадынхан болдог, малчдын бүтээсэн нэмүү өртөг өөрсдөд нь бус, нийгмийн бусад давхарга, хүрээнд зориулагдаж байсан юм. Тиймээс сум-нэгдлийн тогтолцоо энэ хэв загвараараа цаашид оршин тогтнох аргагүй болж, 1990 оны ардчилсан хувьсгалын шуурганд цохиулан үгүй болсон билээ. Гэсэн хэдий ч чамгүй урт хугацаанд оршин тогтнож, түүхэн ул мөрөө нэгэнт үлдээсэн эл тогтолцоо, тухайн цаг үеийн аж ахуй, эдийн засгийн олон талт үйл ажиллагааг

⁵⁸ Алтантөгс Н., Дэлгэржаргал П., Төрдалай Р., Чинзориг Б. (2023). *Сум-нэгдлийн тогтолцоо* (Малчин өрх-Нэгдэл-Улс). Ред. П.Дэлгэржаргал. Соёмбо принтинг ХХК. Улаанбаатар, т. 393-396

бид судлан шинжлэх, эерэг, сөрөг үр дагавар, туршлага, сургамжаас нь суралцах шаардлага эдүгээ бидний өмнө зүй ёсоор тавигдаж байна. Улс орныг бүхэлд нь хамарсан энэ том салбарын бүх талын асуудлыг нэг удаагийн төсөл судалгааны хүрээнд бүгдийг хамруулан авч үзэх аргагүй гэдгийг цохон тэмдэглэе. Тиймээс дутуу дулим, цаашид анхаарах, гүнзгийрүүлэн судлах, судалгааны хүрээгээ тэлэх, бүсчлэн судлах, дотоод амьдралын гүнд нь илүүтэй орж судлах шаардлага буй хэдий ч энэхүү судалгаа нь энэ чиглэлээр сүүлийн жилүүдэд огт хөндөгдөлгүй орхигдож ирсэн асуудлыг ул суурьтай судлан шинжлэх ажлын эхлэлийг тавьсан, ерөнхий дүр зургийг тод томруун гаргасан, чухал үнэ цэнтэй ажил болжээ гэж үзэж байна.

Эцэст нь тэмдэглэхэд, Н.Алтантөгс, П.Дэлгэржаргал, Р.Төрдалай, Б.Чинзориг нарын хамтран туурвисан “Сум-нэгдлийн тогтолцоо (Малчин өрх-Нэгдэл-Улс)” гэх энэхүү хамтын нэгэн сэдэвт бүтээл социализмын жилүүд дэх БНМАУ-ын УААА-н нэг гол салбар болох МАА-н түүх, түүний дотор сум-нэгдлийн тогтолцоог тойрсон бүх талын судалгааг цаашид улам нарийсган гүнзгийрүүлж, үргэлжлүүлэн судлах таатай эхлэл, хөрс суурийг нэгэнт тавьж чаджээ гэдгийг итгэл төгс хэлэх байна.

ЗОХИОГЧДЫН ТАНИЛЦУУЛГА

Б.Батсүрэн.	МУИС-ийн Түүхийн тэнхимийн дэд профессор, доктор
Д. Идэр.	МУБИС-ийн Түүхийн тэнхимийн багш, доктор
П.Дэлгэржаргал.	МУИС-ийн Түүхийн тэнхимийн профессор, доктор
Р.Хас-Очир.	Өвөр Монголын Багшийн их сургуулийн багш, МУБИС-ийн докторант
Г.Баярмаа.	Богд хааны ордон музейн Эрдэм шинжилгээний ажилтан, МУИС-ийн Түүхийн тэнхимийн докторант
О.Одсүрэн.	Улаанбаатар хотын музейн эрдэм шинжилгээний ажилтан
Н.Алтантөгс.	МУИС-ийн ШУС-ийн дэд захирал, доктор
Ц.Гантулга.	МУБИС-ийн Түүхийн тэнхимийн профессор, доктор